



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2023/08/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг

2023 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 99014247 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Болормаа

Утас: 80077408 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК

Утас: 99099119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлчээр усжуулалттай холбоотой мэдээллийн санг 75.0 сая төгрөгөөр хүлээн авсан нь бараа материалын үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

Аудитын гол асуудал

Байгууллагын данс бүртгэлтэй нийт 59.1 сая төгрөгийн өртөгтэй трактор болон ургамал хамгааллын бодис цацагч, сийрүүлэгч манагч машин механизмыг 1 иргэнд, 94.0 сая төгрөгийн өртөгтэй үйлдвэрлэлийн зориулалттай товчний нүх оёх болон товч хадах оёдлын машин, андройд системийн таблетыг 2 аж ахуйн нэгжид үнэ төлбөргүй ашиглуулж байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

016000019

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	152.1	229.4
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,661.8	2,743.6
Нийт хөрөнгийн дүн	2,813.9	2,973.0
Нийт өр төлбөрийн дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,813.9	2,973.0
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,813.9	2,973.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	515.1	952.4
Үйл ажиллагааны зардлын дүн	635.9	773.7
Үйл ажиллагааны үр дүн	(120.8)	178.7
Үйл ажиллагааны бус үр дүн	(16.1)	(19.6)
Үйл ажиллагааны нийт үр дүн	(136.9)	159.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,950.8	2,813.9
Тайлант оны үр дүн	(136.9)	159.1
Эцсийн үлдэгдэл	2,813.9	2,973.0
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	480.3	611.9
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	475.0	606.8
Үйл ажиллагааны ЦМГ	5.3	5.1
Хөрөнгө оруулалтын ЦМГ	5.3	(5.1)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	-	-
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.0
Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	342.7	321.6
Урсгал зардал	342.7	321.6
Хөрөнгийн зардал	-	-
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	342.7	321.6
Улсын төсвөөс санхүүжих	342.7	321.6
Орон нутгийн төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Тус байгууллагын тээврийн хэрэгсэл нь 5 сараас 12 сарыг дуусталх хугацаанд аймгийн төвд 700км замыг туулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 “Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй тул 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага бичигдээгүй

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Бараа материал данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын бараа материал дансанд бүртгэлтэй малыг нас дэвшлүүлэн бүртгээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаалаар баталсан стандартын 6.4.1 “Тайлант хугацааны үйлдвэрлэлийн зардлыг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ба биологийн хөрөнгө, түүний нас дэвшилт, төлд нь тодорхой сууриар хуваарилан шингээнэ” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн яамнаас баталсан биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандартыг баримтлан ажиллаж малын нас дэвшилтийг бүрэн хөтөлж санхүүгийн тайландаа тусган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулга хийгдээгүй												
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/						
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Биологийн хөрөнгийг нас дэвшүүлээгүй	1						1					
Дүн	1						1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/									
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Алдаа илрээгүй									
Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Төрийн хэмнэлтийн тухай хууль	1	0.3	1	0.3					
Дүн									
Нийт дүн	1	0.3	1	0.3					

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			